

Д.Мягмарсүрэн  
Улс төр судлалын тэнхимийн магистрант

### Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо

**Өгүүлийн товч утга:** Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо, түүний бүтэц зохион байгуулалт, гишүүнчлэл, үйл ажиллагааны чиглэл, салбарууд, тэдгээрийн онцлог, явуулж буй бодлого, цаашдын зорилт, зорилго

**Түлхүүр үг:** ОУ-ын Улс төрийн шинжлэх ухааны холбоо ( International Political Science Association .IPSA), дэлхийн конгресс,

Олон улсын улс төр судлаачдын тэргүүлэх байгууллага болох Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо (International Political Science Association (IPSA) 1949 онд ЮНЕСКО-гийн ивээл дор Парист байгуулагдсан. Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо бий болсон нь улс төр судлалын хөгжлийг чанарын шинэ шатанд гаргаж, улмаар дэлхийн хамтын нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдөж, дэмжигдсэн шинжлэх ухаан болж чадсан юм. Уг нийгэмлэг улс төрийн шинжлэх ухааны бүхий л бүтэц тогтолцооны академик түвшин, улс төрийн ухааны судалгаа шинжилгээний зохион байгуулалт болон улс төр судлаачдын олон улсын хамтын ажиллагааны өргөжилтэд чухал үүрэг роль гүйцэтгэсэн байна.

**Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо /ОУУТШУХ/-ийн зорилго, бүтэц зохион байгуулалт.** ОУУТШУХ-ны үндсэн дүрэмд тусгаснаар түүний үндсэн зорилго нь үйл ажиллагааны дараах чиглэлээр дамжуулан дэлхий дахинд улс төрийн шинжлэх ухааны хөгжлийг хангах явдал бөгөөд үүнд: бүс нутгийн ба үндэсний хэмжээний улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг, холбооны хөгжил төлөвшлийг хангах, улс төрийн шинжлэх ухаанд гарсан амжилт ололтын тухай мэдээллийг түгээхэд туслах, улс төр судлаач-эрдэмтдийн харилцааг өргөжүүлэхийн тулд улс төр судлалын “дугуй ширээ”-ний маргаан мэтгэлцээн явуулах буюу ОУУТШУХ-ны Дэлхийн Конгрессыг (World Congress) зохион байгуулах, ОУУТШУХ-ны гишүүдэд зориулан улс төр судлалын ном зохиол, шинжлэх ухааны сэтгүүл, албан ёсны мэдээ мэдээлэл хэвлэн нийтлэх, улс төрийн шинжлэх ухааны олон улсын хамтарсан судалгаа явуулахад оршино.

Америк, Канад, Франц болон Энэтхэгийн улс төрийн шинжлэх ухааны холбоо ОУУТШУХ-ны анхны санаачлагч гишүүд болжээ. Тэр үеэс өнөөг хүртэл жил бүр уг байгууллагад дэлхийн бүс нутгийн болон үндэсний нийгэмлэг, холбоод гишүүнээр элссээр байгаа бөгөөд өдгөө бүс нутгийн болон үндэсний хэмжээний улс төрийн шинжлэх ухааны 40 гаруй нийгэмлэг, холбоог нэгтгэсэн олон улсын томоохон байгууллага нэгэнт болжээ.

ОУУТШУХ бүрэлдэхүүндээ бүс нутгийн болон үндэсний холбоо, нийгэмлэг (шинжлэх ухааны академи, институт ба их дээд сургуулийн улс төрийн шинжлэх ухааны салбар, тэнхим) ба хувь хүнийг гишүүнээр элсүүлдэг байна. Үүнд дэлхийд тэргүүлэх их сургуулиудын улс төр судлалын 100 орчим тэнхим багтаж байна (тэдгээрийн 80%-ийг баруун европ, хойд америкийн их, дээд сургууль бүрдүүлдэг). Тэрчлэн дэлхийн нэртэй улс төр судлаачдаас бүрдсэн 1-1.5 мянган хүн хувиараа гишүүнээр элссэн байдаг.

ОУУТШУН-ийн бүхий л түвшинд гишүүнчлэл нь төлбөртэй. Хамгийн олон тооны буюу 14 мянга гаруй зохион байгуулагдсан оролцогчтой Америкийн улс төрийн шинжлэх ухааны холбоо хамгийн өндөр татвар (12 мянга хүртэл ам.доллар) төлдөг. Үндэсний хэмжээний улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг, холбоодын төлөх татварын хэмжээ тэдгээрийн бүрэлдэхүүний тоо хийгээд тухайн улсын эдийн засгийн хөгжлийн түвшнээс хамаараад харилцан адилгүй байдаг (1-10 мянган ам.доллар хүртэл).

Гишүүн хувь хүмүүс ОУУТШУХ-ны улс төр судлалын сонгосон хүрээндээ судалгааны байнгын хороонд (улс төр судлалын тулгамдсан сэдвээр англи, франц хэл дээр өөрсдийн мэргэжлийн илтгэл, нийтлэлийг хэлэлцүүлэх зорилгоор илтгэлийн хороонд хандах) нэг удаа оролцоход (биечлэн эсвэл электрон хэлбэрээр) жилд 60 долларын татвар төлөх ёстой. ОУУТШУХ-ны ихэнх гишүүд Барууны орнуудаас байдаг хэдий ч сүүлийн жилүүдэд түүний бүрэлдэхүүнд Дорнын “шинээр аж үйлдвэржсэн орнуудын” улс төр судлаачдын тоо эрс өсч байна. ОУУТШУХ, түүний удирдах байгууллагын бүрэлдэхүүний 25 хүртэл хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлж байдаг. 2000-2003 онд ОУУТШУХ-ны ерөнхийлөгчөөр БНСҮ-ын төлөөлөгч Ким Далчунг ажилласан. Одоо ХБНГУ-ын төлөөлөгч М.Каазе 2006 он хүртэл ерөнхийлөгчөөр ажиллаж байна. ОУУТШУХ-ны ерөнхийлөгчөөр К.Дойч (Харвардын их сургууль, 1976-1979), К.Фридрих (Харвард, 1967-1970), К.Фон Бойме (Гейдельбергийн их сургууль, 1982-1985), Г.О"Доннела (Сан-Паулагийн их сургууль, 1988-1991), Т.Лови (Корнельскийн их сургууль, 1997-2000) зэрэг нэр хүндтэй улс төр судлаачид сонгогдон ажиллаж байсан юм.

ОУУТШУХ-ны үйл ажиллагаанхаа гол үр дүнг “International Political Science Review”(Лондонд улирал бүрт гардаг), “International Political Science Abstracts” (CD хувилбараар Парист хэвлэдэг) гэх мэт улс төр судлалын нэр хүндтэй сэтгүүлүүдэд нийтэлдэг. Тэрчлэн “Participation. Bulletin of the International Political Science Association” сэтгүүл ОУУТШУХ-ны өдөр тутмын үйл ажиллагааны тухай мэдээлэл нийтэлдэг байхад, ОУУТШУХ, түүний Дэлхийн конгресс, Судалгааны байнгын хороо, хэвлэл нийтлэл зэрэг ажил хэргийн талаар мэдээ мэдээлэл нь интернет дэх албан ёсны сайт ([www.ipsa.ca](http://www.ipsa.ca)) дээр байрладаг.

ОУУТШУХ-ны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулахад улс төрийн шинжлэх ухааны тулгамдсан асуудлаарх олон улсын судалгааны байнгын хороо чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Хороо бүр Дэлхийн конгрессын салбаруудад зориулсан зохих баримт материалыг бэлтгэх, Конгрессын завсарт дор хаяж нэг удаа “дугуй ширээ”-ний буюу олон улсын бага хурал зохион явуулах үүрэгтэй. Өдгөө 50 гаруй судалгааны байнгын хороо ажиллаж байна<sup>1</sup>.

Судалгааны байнгын хороо ихэнх төлөв Дорнын улс орнууд болон Барууны тэргүүлэх их сургуулиудын улс төрийн шинжлэх ухааны салбар хэлтэст

<sup>1</sup> Улс төрийн шинжлэх ухааны арга, концепци (хороо №1), Улс төрийн элит (№2), Европын холбоо (№3), Хөгжих буй орнууд дахь төрийн хүнд суртал (№4), Улс төр ба орон нутгийн удирдлагын харьцуулсан судалгаа (№5), Улс төрийн социологи (№6), Хөгжих буй улс үндэстнүүд ба эмэгтэйчүүд, улс төр (№7), Хууль тогтоох байгууллагын мэргэжилтнүүд (№8), Эрх зүйн тогтолцооны харьцуулсан шинжилгээ (№9), Шинжлэх ухаан ба улс төр (№11), Биологи ба улс төр (№12), Харьцуулсан хэтий хандлага дахь ардчилал (№13), Улс төр ба угсаатан (№14), Улс төрийн ба соёлын газарзүй (№15), Нийгэм улс төрийн плюрализм (№16), Даяаршил ба удирдлага (№17), Ази, Номхон далайн судалгаа (№18), Жэндериийн бодлого ба улс төр (№19), Улс төрийн санхүүжилт ба улс төрийн авилгал (№20), Улс төрийн нийгэмшил ба боловсрол (№21), Улс төрийн коммуникаци (№22), Арми ба нийгэм (№24), Эрүүлийг хамгаалахын харьцуулсан бодлого (№25), Хүний эрх (№26), Засгийн газрын бутэц, зохион байгуулалт (№27), Харьцуулсан федерализм ба холбооны улс (№28), Психополитик (№29), Улс төрийн сэтгэл эзү (№31), Төрийн удирдлага ба засаг захиргаа (№32), Улс төр судлал шинжлэх ухаан болох нь (№33), Төлөөллийн байгууллага ба сонгуулийн тогтолцооны харьцуулсан шинжилгээ (№34), Технологи ба хөгжил (№35), Улс төрийн засаглал (№36), Улс төрийн хөгжлийг дахин боловсруулах (№37), Улс төр ба бизнес (№38), Нийтийн сайн сайхан байдлын төр ба хөгжих буй орнууд (№39), Дэлхийн шинэ дэг журам (№40), Геополитик (№41), Хуваагдмал улс үндэстний системийн интеграци (№42), Шашин ба улс төр (№43), Цэргийн засаглал ба “гурав дахь ертөнцийн” ардчилах явц (№44), Олон улсын чанарын бодлого (№45), Экологийн глобал өөрчлөлт (№46), Орон нутаг-глобал түвшний харилцаа (№47), Захиргааны соёл (№48), Социализм, капитализм, ардчилал (№49), Хэл ба улс төр (№50), Орчин үеийн Хойд Африкийн улс төрийн судалгаа (№51), Жендер, даяаршил ба ардчилах явц (№52).

тулгуурладаг хэдий ч сүүлийн арван жилд барууны бус улс орнуудыг сонгож, улмаар тэдгээр орнуудад өөрсдийн нүүдлийн “дугуй ширээ”-г хөтлөн явуулах болсон. Харьцуулсан улс төр, улс төрийн институтийн ба улс төрийн үйл байдал, дэлхийн бодлого, глобалистикийн хорооны үйл ажиллагаанд хамгийн олон улс төр судлаачид оролцдог байхад улс төр дэх эмэгтэйчүүдийн үүрэг роль болон арга зүйн хороонд хамгийн цөөн тоогоор хамрагддаг байна. Судалгааны хорооны гишүүнчлэл ОУУТШУХ-ны бүх гишүүдэд нээллтэй.

Судалгааны байнгын зөвлөл, ОУУТШУХ-ны ивээл дор явагддаг эрдэм шинжилгээний ажлын бусад хэлбэрийн хүрээнд улс төрийн шинжлэх ухааны тулгамдсан асуудал, нөхцлийн талаар олон зуун эрдэм шинжилгээний тодорхой илтгэлийг янз бүрийн орнуудад бэлтгэддэг байна. Жишээлбэл, 2003 онд “Улс төрийн санхүүжилт ба авилгал”-ийн хорооноос канадын сонгуулийн комиссын албан ёсны төлөөлөгчдийн оролцоотойгоор “Ардчилал ба улс төрийн намын санхүүжилт” сэдэвтэй олон улсын симпозиумыг Квебек хотноо зохион явуулжээ.

**ОУУТШУХ-ны олон улсын их хурал (конгресс).** ОУУТШУХ-ны дээд байгууллага бол Зөвлөл бөгөөд зохион байгуулалт, санхүүжилтийн бодлогыг тодорхойлж, хөтөлбөрийн баримт бичигт өөрчлөлт оруулах (2/3 саналаар), ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч болон Гүйцэтгэх хороог (үндэсний хэмжээний улс төрийн шинжлэх ухааны холбоо, нийгэмлэгийн 18 гишүүнээс бүрдэнэ) сонгох асуудлыг шийдвэрлэдэг. Конгрессын хоорондох хугацаанд бүрэн эрхээ Гүйцэтгэх хороонд шилжүүлнэ.

ОУУТШУХ-ны үйл ажиллагаанд гурван жилд нэг удаа хуралдах Дэлхийн Конгресс буюу их хурал чухал үүрэг роль гүйцэтгэдэг. Улс төр судлаачдын Конгресс явуулах үед л ОУУТШУХ-ны Зөвлөлийн чуулган, Гүйцэтгэх хорооны бүрэлдэхүүний өөрчлөлт сэлгээг хийдэг байна. Дэлхийн Конгресс улс төрийн шинжлэх ухааны зангилаа асуудлуудыг авч хэлэлцэнэ.

ОУУТШУХ-ны Дэлхийн Конгресст оролцох албан ёсны урилгыг авахын тулд түүний гишүүн байхаас гадна, Конгрессыг зохион байгуулах хороонд улс төр судлалын илтгэлийн сэдвээ урьдчилан зөвшөөрүүлэх, оролцогчийн татвар болох 220 долларыг төлөх ёстой. ОУУТШУХ өөрийн хороо, Конгресст оролцох залуу улс төр судлаачдыг ихээр дэмждэг бөгөөд С бүлэг буюу хөгжиж буй орнуудаас оролцогч 30-аас доош насныханд тодорхой хөнгөлөлт үзүүлдэг.

Дэлхийн Конгресс эхний арваад жилийн хугацаанд..(1949-1979) тухайн бүс нутаг дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжил, Холбооны удирдлагад тогтсон хүчний харьцааг тусган Баруун Европ, Хойд Америкийн орнуудад гол төлөв явагдаж байв. 1970-аад оноос Конгресс дахь улс төр-газар зүйн нөлөөлөл өөрчлөгдөн, дэлхийн бусад газар оронд тухайлбал, Москва (1979), Рио-де-Жанейро (1982), Буэнос-Айрес (1991), Сөүл (1997) зэрэг хотуудад явагдах болсон. Гэвч ОУУТШУХ-ны Дэлхийн Конгресс Дорнод Европ болон Өмнөд Азид ялангуяа уг байгууллагыг үндэслэгчдийн нэг Энэтхэгийн улс төрийн шинжлэх ухааны холбооны эх нутагт өнөөг хүртэл явагдаагүй байна. Ээлжит Конгрессыг Хятад болон ОХУ-ын үндэсний улс төрийн шинжлэх ухааны холбооны нэр хүнд өсөж буй хийгээд тухайн орнуудад хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн туршлагыг дэлхий нийтийн сонирхлыг татаж байгаатай холбогдон тэдгээр улсуудад зохион байгуулах тухай асуудлыг идэвхтэй тавьж байна.

Анхны Конгресст 23 орноос 80 хүн оролцож, нийт 80 илтгэл хэлэлцэж байсан сүүлийн буюу 2003 онд ӨАБНУ-ын Дурбан хотноо зохиогдсон их хуралд 74 орноос 1400 эрдэмтэн, судлаачид оролzon, 1500 гаруй илтгэл хэлэлцсэн явдал уг байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ хэрхэн өргөжсний бодит жишээ юм.

ОУУТШУХ-ны сүүлийн арван жилд зохион явуулсан Конгресст “Цаг хугацаа, орон зай ба улс төр” (Эдинбург, 1976), “Энх тайван, хөгжил, мэдлэг: улс төрийн шинжлэх ухааны оруулсан хувь нэмэр” (Москва, 1979), “Төрөөс ангид нийгэм” (Рио-де-Жанейро, 1982), “Өөрчлөгджэх буй төр, түүний үндэсний ба олон

улсын хамтын нийгэмлэгтэй харицлах харилцан үйлдэл” (Парис, 1985), “Глобал улс төрийн шинжлэх ухаан” (Вашингтон, 1988), “Улс төр дэх төв ба зах хязгаар: харилцан хамаарал ба засаглалын тэгш бус чанар” (Буэнос-Айрос, 1991), “Ардчилах асуудал” (Берлин, 1994), “Мөргөлдөөн ба дэг журам” (Сөүл, 1997), Дэлхийн капитализм, удирдлага ба хоршоолжилт: Энэ мянган корпорацийн эрин байх уу?” (Квебек, 2000) нэрийн дор явагдсан байна.

**Улс төр судлаачдын XIX Дэлхийн конгресс.** XIX конгресс 2003 оны VI сарын 29-нөөс VII сарын 4-ний хооронд Өмнөд Африкийн Дурбан хэмээх боомт хотод явагдсан. Тухайн улсад чуулга уулзалтыг зохион байгуулах болсон шалтгаан нь 1-рт улс төр судлаачдын конгрессыг Африк тивд өмнө нь явуулж байгаагүй, 2-рт апартеид дэглэмийг халж арьс өнгө, үндэсний ялгаа бүхий хүмүүс хамтран амьдарч, улс төр, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгосон бодит туршлага бүхий ӨАБНУ судлаачдын сонирхлыг татаж байсан, 3-рт ОУУТШХ-ны идэвхтэй гишүүн Африкийн улс төрийн шинжлэх ухааны холбооны 30 жилийн ой тохиосон зэрэгтэй холбоотой.

ОУУТШУ XIX Дэлхийн конгресс “Ардчилал, хүлээцтэй байдал, шудрага ёс: улс төрийн өөрчлөлт шинэчлэлтийн уриа дуудлага” нэрийн дор зохиогдсон бөгөөд чуулга уулзалтын хүрээнд конгрессын долоон ерөнхий салбарын, 12 үндсэн салбарын хүрээнд асуудлыг хэндсөн байна. Үндсэн салбарт: “Өнгөрснийг сэргээхүй: улс төрийн дурсамж”, “Улс төрийн хүлээцтэй чанар”, “Даяаршил”, “Шудрага ёс”, “Арьс өнгө, угсаатан, хүйс”, “Шинэ ардчилал: колонийн төгсгөл ба соёлын үнэт зүйл”, “Космополитизм, эх оронч үзэл ба иргэн”, “Газар нутаг, хүрээлэн буй орчин, өмчийн бодлого”, “Нийгмийн (социаль) бодлогын төлөвшил, хөгжил”, “Тerrorизм, мөргөлдөөн ба хүний эрх”, “Парламент, нам ба сонгууль”, “Шүүх, шүүх тогтолцоо”; ерөнхий салбарын хүрээнд: “Олон нийтийн улс төр ба нийгмийн санаа бодол”, “Улс төрийн коммуникаци ба төр”, “Улс төрийн онол ба сэтгэлгээ”, “Улс төрийн нам ба элит”, “Олон улсын харилцаа ба харьцуулсан улс төр”, “Улс төрийн судалгааны арга зүй, шинэ чиг хандлага” гэсэн салбаруудыг байгуулсан байна.

Дурбаны чуулга уулзалтад оролцогчдын анхаарлын төвд даяаршлын үйл явц, дэлхийн хамтын нийгэмлэг болон улс орнуудад түүний үзүүлэх үр дагаврын талаар дүн шинжилгээ хийх явдал багтаж байв. Конгресс даяаршлыг 1) неолиберал, нэг туйлт, гегемонист 2) улс орнуудын эрх ашиг, нийгмийн шудрага ёсны шаардлагыг харгалзсан олон улсын институтын тогтолцооны даяаршлын удирдлага 3) олон туйлт, макро бүсчлэлийн; 4) утопи шинжтэй хамтын ажиллагааны (өөрийн хүчинд тулгуурласан антиглобалист) гэсэн үндсэн талуудад хуваан авч үзсэн байна.<sup>1</sup>

Ж.Гибсон, Г.О'Доннел, Ф.Шмиттер зэрэг “ардчиллын давалгаа”-ны талаар дагнасан судлаачид даяаршил дэлхий дахинд ардчиллыг тогтооход хүргэхгүй болох талаар цохон тэмдэглэсэн байна. Хөгжих буй олон улс оронд үр ашиггүй засаг төр оршиж, ардчилсан элит төлөвших, бэхжих явцад бэрхшээл тулгарч, улмаар авторитар-корпоратив удирдлагын чиг хандлага хүчээ авч байна. Үлэмж явцуу элитар бүлэглэлийн үүрэг роль өсч буйтай зэрэгцэн улс төрийн өргөн хэмжээний хэлэлцүүлгийн нэр нөлөө илт буурах болсон. АНУ-ын реалист улс төрийн бодлогод шахагдан НҮБ-ийн үзүүлэх нөлөөлөл ч хязгаарлагдах болсон гэж үзсэн байна.

Ш.Доран, Йонг-Кван Юн, Ф.Кохута, Г.Шмидт, П.Жеймс нарын эрдэмтдийн бүтээлд шинжлэн тодорхойлсон “засаглалын циклийн онол” (“Power cycle theory”) чуулганд оролцогчдын сонирхлыг зүй ёсоор татаж байсан. Уг онол улс төрийн бүтцийн элемент (тогтолцоо, төр) болон үйл байдлын аспектыг нэгтгэж, геополитик ба гэрээ хэлэлцээрийн үйл явцад олон хэмжээст судалгаа хийх

<sup>1</sup> Ю.В.Ирхин Международная ассоциация политических наук и XIX всемирный конгресс политологов // Вестн. Моск. Ун-та. Сер.12. Политические науки. 2004. №2

боловцоог олгожээ. Дэлхийн бодлогын тоглогч болох тэр улс хүч нөөцөө харгалзан өөрийн гадаад, дотоод бодлогоо хэрхэн явуулахаа тооцох шаардлагатай гэж онолыг үндэслэгчид үзсэн байна. Тухайн параметрт цэргийн төсвийн хэмжээ, хүн амын тоо, эрчим хүчиний нөөц хангамж, зэвсэгт хүчиний хүчин чадал, газар зүйн байрлал, үндэсний хүсэл зориг, цэрэг, улс төрийн удирдлагын чанар чансаа, цөмийн зэвсэгтэй байдал, тэрчлэн шинжлэх ухаан, технологийн санаачлагын чадвар, бус нутаг дахь тухайн улсын үүрэг роль, болзошгүй зэвсэгт мөргөлдөөний бэлэн байдал зэрэг орно.

ОУУТШУХ-ы дэд ерөнхийлөгч М.Кализе “Web хэл (улс тэр судлалын) бий болгох нь”<sup>1</sup> хэмээх илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд Интернетийн эрин үед улс тэр судлалын боловсролын асуудалд энэ нь тулгамдсан асуудал болж байна гэж тэмдэглэжээ. Улс төрийн шинжлэх ухааны түлхүүр ойлголтод олон хэлний шинжилгээ хийхэд ашиглаж буй “Гиперполитик” компьютерын программыг Италид хүлээн зөвшөөрсөн нь чухал ач холбогдолтой үйл явц болсон. “Гиперполитик” төсөл 1) 5 улсын (АНУ, Их Британи, Франц, Итали, Герман) 4 хэл дээрх улс төрийн шинжлэх ухааны 10 толь бичгээс түүвэр хийж түлхүүр үг, ойлголтыг (улс тэр судлалын ба улс төрийн) сонгох; 2) тухайн ойлголтуудад гүнзгий шинжилгээ хийх зорилгоор 4000 гаруй тойм бичвэрээс (тэргүүлэх улс тэр судлаачдын бүтээлийн болон бичвэрийн эх сурвалж, эрдэм шинжилгээний намтар) шилж сонгох; түлхүүр үг ойлголтын систем хүснэгт зохиоход зориулан логик загвар бүтээх гэсэн турван үндсэн бүрдлийг багтаадаг. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд эх сурвалжийн судалгааны явцад улс тэр судлалын ухагдахууны агуулга цаашлаад зөрчилт болон өрсөлдөгч шинжтэй ойлголтуудын салаа утгыг эзэмших бололцоог олгож өгсөн байна.

<sup>1</sup> Calise M. Does the Web make language? 19<sup>th</sup> IPSA World Congress. Programme6 Durban, 20036 P.13.